# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 38 (371)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай*
- *Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2004 оны аравдугаар сарын 11 № 38 (371)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

375. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай — Дугаар 19 — 716

376. Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай — Дугаар 20 — 716

377. Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай — Дугаар 21 — 716

378. Засгийн газрын гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай — Дугаар 22 — 717

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

379. Д. Дамдиндоржийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай — Дугаар 139 — 718

380. Д. Дамдиндоржийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай — Дугаар 140 — 718

381. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай — Дугаар 153 — 718

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр | Дугаар 19 | Улаанбаатар хот

**Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүрэн эрхийн нь хугацаа дуусгавар болсон тул Намжилын Чинбат, Дамбадаржаагийн Чилхаажав нарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсугэй.

2.Энэ тогтоолыг 2004 оны 9 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр | Дугаар 20 | Улаанбаатар хот

**Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн жаран тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын санал болгосноор Жамсрангийн Бямбадорж, Пунсалмаагийн Очирбат нарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2004 оны 9 дүгээр сарын 28 -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр | Дугаар 21 | Улаанбаатар хот

**Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйл, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын гишүүн, сайдаар доор дурдсан хүмүүсийг томилсугай:

1/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын шадар сайдаар Чүлтэмийн Улааныг;

2/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчны сайдаар Уламбаярын Барсболдыг ;

3/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдаар Нямжавын Батбаярыг ;

4/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар Бадарчийн Эрдэнэбатыг;

5/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдаар Пунцагийн Цагааныг;

6/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад хэргийн сайдаар Цэндийн Мөнх-Оргилыг;

7/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам тээвэр, аялал жуулчлалын сайдаар Гаваагийн Батхүүг;

8/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдаар Цэвэлмаагийн Баярсайханыг;

9/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар Норовын Алтанхуягийг;

10/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Түлш, эрчим хүчний сайдаар Түвдэнгийн Очирхүүг;

11/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, худалдааны сайдаар Сүхбаатарын Батболдыг;

12/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар Цэндийн Нямдоржийг;

13/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар Дэндэвийн Тэрбишдагвыг;

14/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдаар Төгсжаргалын Гандийг;

15/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар Сангажавын Баярцогтыг;

16/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, гамшгийн асуудал эрхэлсэн сайдаар Ухнаагийн Хүрэлсүхийг;

17/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдаар Ичинхорлоогийн Эрдэнэбаатарыг.

2.Энэ тогтоолыг 2004 оны 9 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2004 оны 9 дүгээр сарын 28–ны өдөр** **Дугаар 22** **Улаанбаатар хот**

### Засгийн газрын гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн, Монгол Улсын Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулж Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Уламбаярын Барсболдыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчны сайдын;

Жүгдэрдэмидийн Гүррагчааг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдын;

Аюурзанын Цанжидийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын;

Лувсангийн Эрдэнэчулууныг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад хэргийн сайдын;

Бямбын Жигжидийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Дэд бүтцийн сайдын;

Шийлэгийн Батбаярыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын;

Чүлтэмийн Улааныг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Санхүү, эдийн засгийн сайдын;

Чимиддоржийн Ганзоригийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, худалдааны сайдын;

Цэндийн Нямдоржийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын;

Даржаагийн Насанжаргалыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын;

Пагважавын Нямдаваг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдын;

Өлзийсайханы Энхтүвшинг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2004 оны 9 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 10 дугаар сарын 06–ны өдөр | Дугаар 139 | Улаанбаатар хот

**Д. Дамдиндоржийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөр ажил, албан тушаалд томилогдох болсонтой холбогдуулан Дугажийн Дамдиндоржийг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 10 дугаар сарын 06–ны өдөр | Дугаар 140 | Улаанбаатар хот

**Д. Дамдиндоржийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1,4 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Дугажийн Дамдиндоржийг Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 10 дугаар сарын 07–ны өдөр | Дугаар 153 | Улаанбаатар хот

**Элчин сайдыг эгүүлэн татах томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Балбын Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ойдовын Нямдаваag эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Балбын Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жанцангийн Гөлгөөг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар- 12,
Төрийн ордон
☎ 329612
Индекс 14003.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 1